

Бага, дунд сургуулийн бүх зөвлөхүүд таны хүүхдийн ангид *Хоёр дахь Алхам* сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгааг та бүхэн мэдэж байгаа биз ээ. *Хоёр дахь алхам* хөтөлбөр нь хүүхдүүдэд

бусадтай харьцах, сургууль, хамт олны дунд идэвхтэй байх зэрэг чухал үр чадваруудыг эзэмшүүлдэг. Одоогийн байдлаар бид үндсэн хөтөлбөр болон дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрүүд нь манай сургуулийг хүн бүхэн сурч болохуйц сурагчдад шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлдэг аюулгүй, газар болгоход чиглэж хэрэгждэг.

Үе тэнгийн дарамт шахалтад өртөж буй сурагчдыг мөн (0-18 насны) хүүхдүүдэд тулгараад буй хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой эмгэнэлт баримтуудыг үндэслэж тэднийг хамгаалахын тулд бид хүүхдийн хүчирхийлэл нь дэлхийн хэмжээний хамгийн том нийгмийн эрүүл мэндийн хямрал гэдгийг хүлээн зөвшөөрсөн билээ.¹ Өнгөрсөн гурван жилийн хугацаанд дүүргийн хэмжээнд анхан шатны зөвлөхүүд *Хоёр дахь алхам* хүүхэд хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Бид энэ жил дахин өвлийн амралтаас өмнө тодорхой нэг хичээлүүдийг K-5 ангиудад заахаар төлөвлөж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд сурагчид тухайн зүйл аюултай эсэх талаар мэдэж, шийдвэр гаргахад нь туслах арга замуудыг сурах болно: Тухайлбал аюултай эсэх, хүсээгүй байхад нь хувийн орон зайд нь халдах болон биеийн хэсгүүдэд нь хүрэх дүрмүүд (Үүнийг бид сурагчдын усны хувцасаар халхлагдсан хэсэг гэж ойлгоно)-ийн талаар. Ингэснээр сурагчид хүсээгүй байх үед хэн нэгэн биед нь зөвшөөрөлгүй хүрэх, биеийн хэсгүүдэд хүрэхэд мөрдөх дүрмийг биелүүлээгүй тохиолдлуудад үгүй гэж хэлж сурах ба мөн, аюултай нөхцөл байдлын талаар насанд хүрэгчдэд хэлж, тэднээс тусламж хүсч тухайн аюултай нөхцөл байдлаас гарахын тулд өөртөө итгэлтэй байхыг дадлагаар эзэмшинэ.

Гэр бүл бол үр хүүхдүүдийн аюулгүй байдлын хангах нэн чухал орон зай тул бид та бүхэнд аль болох илүү их сургалт мэдээлэл өгөхийг хичээдэг:

- Хүүхэд хамгааллын алба эсвэл *Хоёр дахь Алхам* хөтөлбөрийн талаар асуух зүйл байвал хүүхдийнхээ сургуулийн зөвлөхтэй холбоо барина уу. Таныг сургуулийн зөвлөхтэй хамт заагдсан хичээлүүдийг хянаж үзэхийг урьж байна. АНС-ийн вэб сайт дахь зөвлөгөө өгөх хуудсанд манай *Хоёр дахь алхам* хичээлийн талаархи нэмэлт мэдээллүүд орсон байгаа. Мөн түүнчлэн АНС-ийн багш нар болон сайн дурын ажилтнууд эдгээр асуудлаар жил бүр сургалт явуулдаг болохыг энд дуулгая.
- Бид энэ жил анх удаагаа асран хамгаалагчдыг насанд хүрэгчдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх ажилд оролцохыг уриалж байна, ингэснээр та хүүхдээ илүү сайн дэмжиж чадна. Энэхүү холбоосоор орж дэлгэрэнгүй мэдээлэл авна уу: <https://www.signupgenius.com/go/20F0A45ACA829A6FD0-stewards1>

Туслалцаа дэмжлэг авах арга замууд:

- Арлингтон хотод байгаа хүүхдийг аюулд өртөж болзошгүйг гадарласан эсвэл мэдсэн тохиолдолд Арлингтон дахь Хүүхдийн Хамгаалах Үйлчилгээ (703 228 1500) руу утасдаж холбоо бариарай. Утас 24/7 цагийн турш нээлттэй.

- Хэрэв танд Арлингтон хотоос өөр газар байгаа хүүхдэд эсвэл урьд өмнө тохиолдож байсан ямар нэгэн асуудалд нэмэлт тусламж, дэмжлэг шаардлагатай байгаа бол

эдгээр 2 тусгай дугаарлуу 24/7 цагийн аль ч үед холбогдон сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдтэй ярилцахыг санал болгож байна.

- The Childhelp National Child Abuse Hotline – 1-800-4-A-CHILD (1-800- 422- 4453)
- Darkness to Light – 1-866-FOR-LIGHT (866-367-5444) or text LIGHT to 741741

Манай сургуулийг хүн сурч боловсроход ээлтэй, аюулгүй газар болоход туслалцаа үзүүлж буйд тань баярлалаа.

Хүндэтгэсэн,

Diane Reeser

Сургуулийн Зөвлөхүүд

¹ <https://www.d2l.org/the-issue/>